



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 4/683

Ховд

Барилгын захиалагчийн хяналтын орон тооны бус
ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2, 35.1.4 дэх
заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймагт 2019 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө
оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд барилгын захиалагчийн хяналтыг
хэрэгжүүлэх орон тооны бус ажлын хэсгийг Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын дэргэд дараахь бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Р.Цэдэнбал -Монгол улсын гавъяат барилгачин,
өндөр настан /зөвшилцсөнөөр/

Гишүүд: Р.Сандуйжав - Монгол улсын гавъяат барилгачин,
өндөр настан /зөвшилцсөнөөр/

Г.Цогтдэлгэр -Ахмад барилгачин /зөвшилцсөнөөр/

Э.Нямдорж -Барилгын мэргэшсэн инженер

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын барилгын асуудал хариуцсан
мэргэжилтэн

2.Барилгын захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх Газрын харилцаа,
барилга, хот байгуулалтын газрын удирдлага дор хамтарч хяналтыг хэрэгжүүлж
ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Р.Цэдэнбал/-д үүрэг болгосугай.

3.Холбогдох зардал, томилолт олгох, унаа автомашин ашиглуулан хамтран
хяналтыг хэрэгжүүлж арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засаг даргын
Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт,


хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Ц.Ганданповрон/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

4.Хууль, эрх зүйн баримт бичиг, барилгын норм ба дүрэм, багаж тоног төхөөрөмжийг ашиглуулан хамтран хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Б.Баярсүх/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/ нарт даалгасугай.

5.Барилгын захиалагчийн хяналтыг холбогдох хууль, журам, дүрмийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал бүрээр гаргаж танилцуулж байхыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т үүрэг болгосугай.

6.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/223 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

